

ОУИТБС –ИЙН 2022 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨЛ

1. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООТОЙ ХОЛБООТОЙ ҮҮСЭХ АВЛИГЫН ЭРСДЭЛ

Тухайн төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол, албаны эрх мэдэл, албан үүргийн давуу байдлаа ашиглан нэмэлт орлого олох сэдэл, нөгөө талаас компани, хуулийн этгээдүүд нь бизнесийн үйл ажиллагаагаа хурдасгах, цаг хожих, шат дамжлагыг алгасах, хуулиар ногдох үүрэг, төлбөр, татвараас чөлөөлөгдөх, зардлаа багасгах эрмэлзлэлээс үүдэн энэ төрлийн авлига гардаг.

Зорилт 1.1

Хүний оролцоог багасгах, шийдвэр гаргалтыг ил тод болгох хүрээнд тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх шат дамжлагуудад гарах бүх шатны (яамд, агентлаг, орон нутаг) шийдвэр болон шийдвэр гаргалтын процессыг ил тод болгох, цахимжуулах, мөн шинээр хэлэлцэх “Ашигт малтмалын тухай хууль”-д ил тод болгох болон цахимжуулах талаар санал оруулах.

Санал болгож буй үйл ажиллагаа	Хариуцагч	Хяналт тавих байгууллага	Хийгдэх хугацаа	Дараагийн алхмууд	Гарц/Хүрэх үр дүн/Ахицын шалгуур үзүүлэлтүүд
1 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, гэрээ хэлэлцээр, уулын ажлын төлөвлөгөө, тайлан, байгаль орчны үнэлгээ, тайлан, орон нутгийн болон мэргэжлийн хяналтын мөн эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтын талаарх нарийвчилсан үнэлгээ хийх	АМГТГ, ОУИТБС-ын Ажлын алба	УУХҮЯ	2022 он 1-р улирал	Шийдвэр, түүнийг шийдвэрлэж буй хугацааг олон нийтэд ил болгох	Шийдвэр гаргалтын талаарх нөхцөл байдлын тайлан
2 Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд тусгай зөвшөөрөл, гэрээ хэлэлцээр, уулын ажлын төлөвлөгөө, тайлан, байгаль орчны үнэлгээ, тайлан, орон нутгийн болон мэргэжлийн хяналтын мөн эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах бүх процессыг цахим болгож, олон шат дамжлагагүй болгох, ил тод, нээлттэй байх, хөндлөнгийн хяналттай байх зохицуулалтыг тусгах	ОУИТБС-ын Ажлын алба	УУХҮЯ, АМГТГ, БОАЖЯ, ХЗДХЯ	2022 он 3-р улирал	Саналын төслөө УУХҮЯд хүргүүлэх	Хуулийн төсөлд оруулах саналыг эцэслэн гаргах

3	<p>Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд тусгай зөвшөөрөл, гэрээ хэлэлцээр, уулын ажлын төлөвлөгөө, тайлан, байгаль орчны үнэлгээ, тайлан, орон нутгийн болон мэргэжлийн хяналтын мөн эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой олон нийтэд нээлттэй мэдээллийг “нээлттэй өгөгдлийн формат”-аар ил болгох талаарх санал, зөвлөмжийг АМГТГ, УУХҮЯ болон бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэх, ОУИТБС-ын хүрээнд мэдээллийг ил болгохоор хамтран ажиллах</p>	<p>ОУИТБС-ын Ажлын алба</p>	<p>УУХҮЯ, ХЗДХЯ</p>	<p>2022 он 4-р улирал</p>	<p>Хүргүүлсэн зөвлөмжтэй холбогдуулан уулзалт зохион байгуулах</p>	<p>Зөвлөмж хэрэгжих</p>
4	<p>“Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг дараах чиглэлд шинэчлэх, боловсронгуй болгох саналыг УУХҮЯ-д хүргүүлж, шийдвэрлүүлэх. Үүнд:</p> <p>1. Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулж буй журмын зохицуулалтыг нарийвчлах, тухайлбал, процессыг цахимжуулах, үйл ажиллагааг нь ил тод, нээлттэй болгох;</p> <p>2. Сонгон шалгаруулалт явуулах Комисст (ажлын хэсэгт) иргэний нийгэм болон мэргэжлийн, хөндлөнгийн байгууллагын төлөөллийг оруулдаг зохицуулалтыг бий болгох,</p> <p>3. Комисс нь шийдвэр болон шийдвэр гаргах үйл явцаа нээлттэй байлгаж, гаргасан шийдвэрийн үндэслэлээ тодорхой танилцуулдаг жишиг тогтоох.</p>	<p>ОУИТБС-ын Ажлын алба</p>	<p>УУХҮЯ, АМГТГ, МҮХАҮТ, Холбоод</p>	<p>2022 он 2-р улирал</p>	<p>Журамд оруулах тодорхой саналыг боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран хэлэлцүүлэг хийх</p>	<p>Журамд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгах</p>

2. КОМПАНИУД ШУДАРГА ӨРСӨЛДӨӨНӨЭС ЗАЙЛСХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ АВЛИГЫН ЭРСДЭЛ

Олборлох салбарт ажиллаж байгаа компаниуд шинэ өрсөлдөөний эрсдэлээс зайлсхийх; борлуулалт, үйлчилгээ, нийлүүлэлт, туслан гүйцэтгэлийн зах зээлээ алдахгүй байх, нэмэгдүүлэх; бүх төрлийн зөвшөөрөл, лицензээ хадгалах, шинэ өрсөлдөгчийг оруулахгүй байх; бүтээгдэхүүн түүхий эдийн үнэ болон бусад ажлын тогтоосон үнэлгээг барьж байх сонирхлоос үүдэн бий болдог авлига.

Зорилт 2.1

Олборлох салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн аж ахуйн нэгж, салбарын тэргүүлэх компаниуд, хуулийн этгээд нь улс төрд нөлөө бүхий этгээдүүдийг удирдлага, ТУЗ-ийн гишүүн, бусад удирдах албан тушаал, зөвлөхийн орон тоонд ажилд авч байгаа шалгуур, сонгон шалгаруулалт, шийдвэрийг ил тод болгох.

Санал болгож буй үйл ажиллагаа	Хариуцагч	Хяналт тавих байгууллага	Хийгдэх хугацаа	Дараагийн алхмууд	Гарц/Хүрэх үр дүн/Ахицын шалгуур үзүүлэлтүүд
1 Өмнө нь болон одоо улс төрд нөлөө бүхий этгээдүүд, ашиг хүртэгч эздийн мэдээллийг цуглуулах, ил тодоор мэдээлэх, мэдээллийг магадлан шалгах талаар болон бусад шаардлагатай зохицуулалтуудыг хамруулсан холбогдох хуулиудын нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэх	ОУИТБС-ын ажлын алба	УУХҮЯ, ХЗДХЯ, АТГ	2022 он 1, 2-р улирал	Хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу шалгуур, сонгон шалгаруулалт, шийдвэрийн талаарх мэдээлэл авах маягт, тайлангийн загвар, журмыг боловсруулах	Холбогдох хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийн эцсийн хувилбар; салбарын яамдаас авсан санал/ Холбогдох сайд нараас 1 нь хэвлэлд ярилцлага өгсөн байна/ ЗГХЭГ- т хүлээлгэн өгсөн байна
2 ОУИТБС-ын ашиг хүртэгч эздийн мэдээллийг нягтлах, шалгах үйл ажиллагааг холбогдох байгууллагын үйл ажиллагаанд хэвшүүлэх, нэгтгэл тайлангийн ажлын даалгаварт санамсаргүй түүврийн аргаар ашиг хүртэгч эздийн мэдээллийг дахин баталгаажуулах	АМГТГ, ОУИТБС-ын Ажлын алба	УУХҮЯ, ХЗДХЯ, АТГ	2022 он 1, 2-р улирал	Мэдээллийн маягтыг шинэчлэх нягтлах, шалгах ажиллагааг хэвшүүлэх, нэгтгэл тайлангийн ажлын даалгаварт тусгах	Үйл ажиллагаа хэвших, ашиг хүртэгч эздийн мэдээлэл баталгаажсан байна
3 Өмнө нь болон одоо улс төрд нөлөө бүхий этгээдийг олборлох салбарын компанид албан тушаалд томилох шалгуур, сонгон шалгаруулалт, шийдвэрийн талаарх	АМГТГ, ОУИТБС-ын Ажлын алба	УУХҮЯ	2022 он 1, 2-р	Мэдээлэл авах явдлыг эхлүүлэх; шаардлагатай сургалт, зааварчилгааг цахим хэлбэрээр	Мэдээлэл авах маягт; Тайлангийн загвар; Журам батлагдсан байна/АМГТГ-ын дарга

	мэдээлэл авах маягт, тайлангийн загвар, журмыг боловсруулах, ОУИТБС-ын хүрээнд батлуулах			улирал	боловсруулж ОУИТБС-ийн цахим хуудсанд байршуулах	хэвлэлд танилцуулга хийсэн байна/Цахим орчинд байршуулсан байна.
4	Олборлох салбарын ТӨК-ийн эрх бүхий албан тушаалтны ХАСХОМ-ыг ОУИТБС-ын хүрээнд нягтлах хөндлөнгийн үнэлгээг АТГ-тай хамтран хийх журам боловсруулах	ОУИТБС-ын Ажлын алба	УУХҮЯ	2022 он 2, 3-р улирал	Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	Журам боловсруулагдсан байна

3. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, ЭРХ ХЭМЖЭЭНЭЭС ШАЛТГААЛАН ҮҮСЭХ АВЛИГЫН ЭРСДЭЛ

Энэ төрлийн авлига нь орон нутгийн удирдлага, төлөөллийн хувийн ашиг сонирхлоос үүдэн авлига авагч талаас бий болохоос гадна хувийн хэвшлийн компани, хуулийн этгээдүүд татвар, төлбөр, хураамжийг аль болох багаар төлөх эсвэл зугтах; мөн хуулиар оногдсон болон орон нутагтай анхлан тохиролцсон бусад үүргүүдээс чөлөөлөгдөх, зайлсхийх; үйл ажиллагааны зардлаа хэмнэж ашгаа өсгөх зорилгоор орон нутгийн удирдлага, төлөөллийн хууль бус нөхцөл болзлыг хүлээн авах, эсвэл хамтран ажиллах, хахууль шан харамж өгөх зэргээр авлига өгөгч талаас мөн үүсдэг авлигын төрөл.

Зорилт 3.1

Олборлох үйл ажиллагаа явуулж байгаа компани, хуулийн этгээдээс орон нутагт үзүүлдэг дэмжлэг, мөнгөн болон мөнгөн бус хандивын талаарх ил тод мэдээллийн үнэн зөв болон иж бүрэн байдлыг олон нийтийн оролцоотой хянах

	Санал болгож буй үйл ажиллагаа	Хариуцагч	Хяналт тавих байгууллага	Хийгдэх хугацаа	Дараагийн алхмууд	Гарц/Хүрэх үр дүн/Ахицын шалгуур үзүүлэлтүүд
1	Компани, хуулийн этгээдээс орон нутагт үзүүлдэг дэмжлэг, мөнгөн болон мөнгөн бус хандивын талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд ойлгомжтой хэлбэрээр мэдээлэх, ОУИТБС-ын дэд зөвлөлтэй хамтран олон нийтийн хяналтын тогтолцоо бий болгох	ОУИТБС-ын Ажлын алба	УУХҮЯ, АТГ	2022 оны 2-р улирал	Мэдээлэл иргэдэд хүрч байгаа эсэх дээр асуулга, тандалт явуулах;	Цуглуулсан мэдээлэл / Орон нутгийн иргэд мэдээллийн дагуу хяналт хийх боломжтой болно

2	Дэмжлэг, мөнгөн болон мөнгөн бус хандивын талаар хийж байгаа ажлуудыг сурталчлах, ойлголт өгөх мөн холбогдох маягт, загвар, журмын талаар орон нутгийн иргэдэд сургалт явуулах	ОУИТБС-ын Ажлын алба	УУХҮЯ, АТГ	2022 он 2, 3-р улирал	Сурталчилгаа, сургалтын үр дүнг тандах	Сурталчилгаа, сургалтын тоо/ Олгогдсон хандив дэмжлэгийн тайлагнал сайжирсан байна/Аймаг сумдын хамрагдалт 50% доошгүй/
3	Дэмжлэг, мөнгөн болон мөнгөн бус хандивын талаарх мэдээллийг тухайн орон нутгийн иргэдэд мэдээлэх, иргэдээс хариу мэдээлэл цуглуулах тал дээр ОУИТБС-ын дэд зөвлөл болон ТББ, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах, үр дүнг нь ОУИТБС-ын нэгтгэл тайланд тусгах.	ОУИТБС-ын ажлын алба	УУХҮЯ, АТГ	2022 он 4-р улирал	ОУИТБС-ын нэгтгэл тайлангийн мэдээллийг орон нутагт сурталчлах	Байршуулсан тоо, хэвлэл мэдээлэлд өгсөн ярилцлага, мэдээ; иргэдийн оролцоотой мэдээлэл шинэчлэгдсэн байдал

3. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, ЭРХ ХЭМЖЭЭНЭЭС ШАЛТГААЛАН ҮҮСЭХ АВЛИГЫН ЭРСДЭЛ

Энэ төрлийн авлига нь орон нутгийн удирдлага, төлөөллийн хувийн ашиг сонирхлоос үүдэн авлига авагч талаас бий болохоос гадна хувийн хэвшлийн компани, хуулийн этгээдүүд татвар, төлбөр, хураамжийг аль болох багаар төлөх эсвэл зугтах; мөн хуулиар оногдсон болон орон нутагтай анхлан тохиролцсон бусад үүргүүдээс чөлөөлөгдөх, зайлсхийх; үйл ажиллагааны зардлаа хэмнэж ашгаа өсгөх зорилгоор орон нутгийн удирдлага, төлөөллийн хууль бус нөхцөл болзлыг хүлээн авах, эсвэл хамтран ажиллах, хажууль шан харамж өгөх зэргээр авлига өгөгч талаас мөн үүсдэг авлигын төрөл.

Зорилт 3.2

Орон нутаг болон олборлох үйл ажиллагаа эрхэлдэг компани, хуулийн этгээдийн хооронд үүсдэг харилцаа (хууль эрх зүй, эдийн засаг, байгаль орчин, нөхөн сэргээлт, хамтын ажиллагаа, хандив тусламж г.м), авлигын эрсдэл, иргэдийн эрх ашиг, оролцоо, олон нийтийн хяналтын талаарх сургалт, соён гэгээрүүлэх ажлыг орон нутгийн иргэдэд зориулан зохион байгуулах

	Санал болгож буй үйл ажиллагаа	Хариуцагч	Хяналт тавих байгууллага	Хийгдэх хугацаа	Дараагийн алхмууд	Гарц/Хүрэх үр дүн/Ахицын шалгуур үзүүлэлтүүд
1	Орон нутгийн иргэд, олон нийтэд чиглэсэн олборлох салбарын авлигын талаарх сургалт, соён гэгээрүүлэх ажлын зорилго, хэрэгцээг тодорхойлж, сургалтын модуль бэлтгэх	ОУИТБС-ын Ажлын алба, АТГ	УУХҮЯ, АТГ	2022 он 1-р улирал	Сургалт, соён гэгээрүүлэх ажлын сэдэв, агуулга, бүтцийг гаргах	Сургалтын агуулга боловсруулсан байна
2	Орон нутгийн иргэд, олон нийтэд чиглэсэн олборлох салбарын авлигын тухай болон иргэдийн оролцооны талаарх сургалт, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөгөө, хуваарийн дагуу орон нутгийн иргэд, олон нийтийн дунд зохион байгуулах	ОУИТБС-ын Ажлын алба, орон нутгийн удирдлага, ТББ	УУХҮЯ, АТГ	2022 он 3, 4-р улирал	Сургалтын явц, иргэдийн хамрагдах байдал, оролцоо, сургалтын нөлөөлөл зэрэг тодорхойлж сургалт, соён гэгээрүүлэх ажлын сэдэв, хүрээ, агуулга, бүтцийг шинэчлэх, өргөтгөх	Орон нутагт хийсэн сургалт, соён гэгээрүүлэх ажлын тоо; хамрагдсан иргэдийн тоо Хандив дэмжлэгийн ил тод байдал хангагдана /Хийгдсэн ажлын тоо 2 доошгүй

3. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, ЭРХ ХЭМЖЭЭНЭЭС ШАЛТГААЛАН ҮҮСЭХ АВЛИГЫН ЭРСДЭЛ

Энэ төрлийн авлига нь орон нутгийн удирдлага, төлөөллийн хувийн ашиг сонирхлоос үүдэн авлига авагч талаас бий болохоос гадна компани, хуулийн этгээдүүд татвар, төлбөр, хураамжийг аль болох багаар төлөх эсвэл зугтах; мөн хуулиар оногдсон болон орон нутагтай анхлан тохиролцсон бусад үүргүүдээс чөлөөлөгдөх, зайлсхийх; үйл ажиллагааны зардлаа хэмнэж ашгаа өсгөх зорилгоор орон нутгийн удирдлага, төлөөллийн нөхцөл болзлыг хүлээн авах, эсвэл хамтран ажиллах, хахууль шан харамж өгөх зэргээр авлига өгөгч талаас мөн үүсдэг авлигын төрөл.

Зорилт 3.3

Орон нутагт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ТББ, хэвлэл мэдээлэлтэй хамтран ажиллах

Санал болгож буй үйл ажиллагаа	Хариуцагч	Хяналт тавих байгууллага	Хийгдэх хугацаа	Дараагийн алхмууд	Гарц/Хүрэх үр дүн/Ахицын шалгуур үзүүлэлтүүд
1 ОУИТБС-ийн зүгээс хийж байгаа ажлаа орон нутагт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд, хэвлэл мэдээлэлд тогтмол танилцуулах, хамтран ажиллах	ОУИТБС-ын Ажлын алба	УУХҮЯ,	2022 оны 1-р улирал	ТББ болон хэвлэл мэдээллийн төлөөлөлтэй хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах	Уулзалтын тоо, хамтран ажиллах төлөвлөгөөг эцэслэх/Нэгдсэн ойлголттой болно.
2 ОУИТБС нь орон нутагт хамааралтай мэдээллийг боловсруулж, холбогдох ТББ, хэвлэл мэдээллийн байгууллага, орон нутгийн иргэдэд хүргэх; цахим хэлбэрээр хариу мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх	ОУИТБС-ын Ажлын алба	УУХҮЯ,	2022 он бүхэлдээ	Мэдээллийн өгөөжийг тандах	Боловсруулсан болон ил тодоор нийтэд хүргэсэн мэдээллийн тоо; мэдээллийн танилцуулга хийсэн тоо/ Нэгдсэн ойлголттой болно.
3 Олборлох салбарт орон нутагт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ТББ, хэвлэл мэдээллийн байгууллагын жагсаалт бэлдэж, ОУИТБС-ын цахим хуудсанд байршуулах, мэдээллийг нийтэд хүргэх, нягтлах	ОУИТБС-ын Ажлын алба	УУХҮЯ,	2022 он бүхэлдээ	Жагсаалтыг шинэчлэх	Боловсруулсан болон ил тодоор нийтэд хүргэсэн мэдээллийн тоо /Орон нутгийн иргэд тухайн орон нутагт нь үйл ажиллагаа явуулж байгаа ТББ –ууд, хэвлэл мэдээллийн талаар мэдээлэлтэй болно

